

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 03/16 дугаар албан бичгийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 20

Улаанбаатар хот

2026 оны нэгдүгээр улиралд өргөдөл шийдвэрлэсэн тухай

Нэг.Ирсэн өргөдлийг шийдвэрлэсэн тухай

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан “Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/62 дугаар захирамжийн 1.1.2-д “Иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг сар бүрийн 25-ны өдөр байгууллагын удирдлагад танилцуулан холбогдох арга хэмжээ авах, өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэн, дутагдал гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах” чиглэл өгсний дагуу өргөдөл, гомдлыг богино хугацаанд тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

Тус газарт 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар байгууллагын албан хаагчдаас 4 өргөдөл, иргэнээс 3, 1800-1200 дугаарын оператороос 1 өргөдөл ирж нийт 8 өргөдлийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд 8 хүсэлт бүртгэгдсэн байна.

Ирсэн 8 өргөдлийг хариу өгсөн хэлбэрээр нь ангилбал:

- ✓ Программ хангамж + тушаалаар 4;
- ✓ Программ хангамж + утсаар хариу өгсөн 2;
- ✓ Программ хангамж + албан бичгээр хариу өгсөн 1;
- ✓ Программ хангамж + утсаар хариу өгсөн+ албан бичгээр хариу өгсөн 1.

2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр 1 өргөдөл шилжин ирж, 9 өргөдөл бүртгэгдсэн байна. Судалж байгаа төлөвтэй 1 өргөдөл байна.

Өргөдлийг ангилан авч үзвэл:

			Хүснэгт-1
№	Ангилал	Өргөдлийн тоо	Өргөдлийн хувь
1	2	3	4
1	Цалинтай чөлөө хүсэх тухай	1	12.50%
2	Ажлаас чөлөөлөгдөх тухай	1	12.50%
3	Дэмжлэг, тусламж хүссэн	2	25.00%
4	Ажилд орох тухай	2	25.00%
5	Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай	3	25.00%
Нийт өргөдлийн дүн			100%

Байгууллагад ирсэн өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 10 цаг 7 минут байна. Энэ нь өмнөх оны жилийн эцсийн өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас 2 хоногоор өссөн үзүүлэлттэй байна. Учир нь тус байгууллагын чиг үүргийн дагуу шууд харьяалан шийдвэрлэхгүй, бусад байгууллагатай хамтран шийдвэрлэх өргөдөл

ирсэнтэй холбоотой байна. Мөн өргөдлийг 4-6 шат дамжлагыг дамжин шилжүүлж, шийдвэрлэсэн байна.

Өргөдлийг шийдвэрлэсэн хугацаагаар нь авч үзвэл:

- ✓ 1-5 хоногт шийдвэрлэсэн 6 өргөдөл,
- ✓ 6-10 хоногт шийдвэрлэсэн 1 өргөдөл,
- ✓ 30 хоногт шийдвэрлэсэн 1 өргөдөл тус тус байна.

Хоёр.Өргөдлийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийсэн тухай

Тайлант хугацаанд өдөрт нь багтаан хүлээн аваагүй 17 зөрчил үүссэн байна. Зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлахад шинээр томилогдсон Бичиг хэргийн эрхлэгч цахим системийг тухай бүр шалган өргөдөл шилжүүлдэг талаар ойлголтгүйгээс, нэгжийн дарга өргөдлийг шийдвэрлэх албан хаагчид өдөрт нь багтаан шилжүүлээгүйгээс зөрчил үүссэн байна.

Цаашид системд өргөдөл ирсэн эсэхийг тухай бүр шалгаж, өргөдөл шилжүүлсэн нэгжийн удирдлагыг тухай бүр шийдвэрлэх албан хаагчид шилжүүлж байх, мөн өргөдлийг бүртгээд шилжүүлсэн албан хаагчид Бичиг хэргийн эрхлэгчийг мэдэгдэж байхыг удирдлагаас үүрэг болгосон.

Тайлант хугацаанд ирсэн 9 өргөдлийг судлан үзэхэд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 5 өргөдөл, албан хаагчдаас 4 өргөдөл ирсэн байна. Тухайлбал: Байгууллагын үндсэн үйл ажиллагаа буюу үнэлгээний хороонд ажиллах хүсэлт 2, тендерийн хугацаа сунгуулах хүсэлт 1, тендерийн үйл ажиллагаатай холбоотой 2, дэмжлэг тусламж хүссэн 2, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 1, цалинтай чөлөө олгох 1 хүсэлт ирснийг хүлээн авч шийдвэрлэн, хариу өгч, ажилласан байна.

Байгууллагын цахим хуудаст улирал бүр өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг байршуулан олон нийтэд ил тод мэдээлж, хэвшсэн байна.

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Д.БАТЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ө.ОЮУНЧИМЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Г.МӨНГӨНЧӨДӨР